**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ 2023 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ**

| Д/д | № | Хийгдэх ажлууд | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэг.Нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд** | | | | | | |
| 1 | 1.1 | Албан хаагчид олгох үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн тогтоох | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | Тус байгууллага нийт 39 албан хаагчидтай ба 36 албан хаагчдад зэрэг дэв, ур чадвар, удаан жил, ажил хавсарсны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцон олгож байна. | 100% |
| 2 | 1.2 | Албан хаагчид улирлын ажлын үр дүн, ур чадварын нэмэгдлийг сар бүр үнэлж, дүгнэн мөнгөн урамшуулал олгох | Улирал бүр | ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан журам, ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалд нийцсэн байх. | 2023 оны эхний хагас жилийн ажлын үр дүнг үнэлж 9-р сард зарим албан хаагчдад үр дүнгийн урамшуулал, 10-р сард ур чадварын нэмэгдэл тус тус олгосон. | 50% |
| 3 | 1.3 | Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр санаачилга гаргаж ажилласан төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулах, Засгийн газрын болон төрийн дээд шагналд тодорхойлох | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын шалгуур үзүүлэлтийг хангасан байна. | Тайлант хугацаанд дарга Ж.Идэрмөнх, хөнгөн атлетикийн дасгалжуулагч Ө.Энэбиш нар спортын салбарт ажилласан хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлэн төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулсан байна. | 70% |
| **Хоёр. "Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох зорилтын хүрээнд"** | | | | | | |
| 4 | 2.1 | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалтад хамруулах | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна. | Байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос "Хувь хүний хөгжил, оролцоо" сэдэвт сургалтыг МСҮТ-ын багш Д.Нямсүрэнгээр удирдуулан нийт ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | 2.2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалтад хамруулах | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар Дорноговь аймаг 10-р сарын 3-5 ны өдрүүдэд хамт олноороо бүсийн уулзалт, хэлэлцүүлэг, спорт, урлагын арга хэмжээнд оролцоод ирсэн. | 70% |
| 6 | 2.3 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна. | Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгууласан "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Шинэ сэргэлтийн бодлого"-ын биеийн тамир, спортын зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх арга зүй сэдэвт сургалтанд дарга, хөнгөн атлетикийн дасгалжуулагч, бичиг хэрэг хүний нөөцийн ажилтан, НБТС-ын арга хэмжээний зохион байгуулалт, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний 4 хүний бүрэлдэхүүнтэй Улаанбаатар хотод сургалтад хамрагдаж, томилолтын зардалд 846,600 төгрөг зарцуулсан.<br>Биеийн тамир спортын салбарын удирдах ажилтны хэлэлцүүлэг, "Эрүүл Монгол" үндэсний чуулганд Улаанбаатар хотод дарга оролцож томилолтын зардал 462,600 төгрөг зарцуулсан.<br>МХСН-ын шигшээ тэмцээнд оролцох тамирчдын мэдээлэл тулгалт хийх ажлаар цахим хариуцсан ажилтан С.Батцэцэг Улаанбаатар хотод оролцож томилолтын зардалд 183,800 төгрөг зарцуулсан байна. | 100% |
| 7 | 2.4 | Албан хаагч нь эрүүл мэндийн шалтгааны улмаас өвдөж, эмчлүүлэх тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж болон тухайн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгагдсан тохиолдолд | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5.4-д "эрүүл мэндийн шалтгааны улмаас өвдөж, эмчлүүлэх тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх" заалт тусгагдсаны дагуу УССТөвийн үйлчлэг О.Баттуул нь амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс засалд орж байгаа тул 500,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | 2.5 | Албан хаагчийн ахуй амьдрал, ар гэрт гачигдал тохиолдвол буцалтгүй тусламж үзүүлэх | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж болон тухайн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгагдсан тохиолдолд | Уг заалт байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5.3-д тусгагдсан. Тайлант хугацаанд ар гэрт нь гачигдал гарсан 2 албан хаагчид нийт 200,000 төгрөг, 100 км замын бензин олгож ажилласан байна. Мөн наадмын талбайн сахиул С.Эрдэнэхүүгийн гэр дээр хүчтэй салхины улмаас талбайн үзэгчдийн суудлын дээвэр унаж гэр нь сүйдсэнийг аймгийн ЗДТГ-аас гэр олгож, буцалтгүй тусламж үзүүлсэн. | 100% |
| 9 | 2.6 | Албан хаагч өндөр насны тэтгэвэр, эрдмийн зэрэг цол хамгаалсан, тэтгэврийн нас хүрсэн тохиолдолд хүндэтгэл үзүүлэх | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж болон тухайн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгагдсан тохиолдолд | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2.7-д Өндөр настны тэтгэвэрт гарч байгаа Төрийн захиргааны жинхэнэ албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн 36 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ба бусад ажилтан, ажилчдад Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу төр засгийн байгууллагад ажилласан хугацаанаас нь хамааруулаад 1 сар ба түүнээс дээш хугацааны дундаж хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгож болно гэж заасан байдаг. Энэ жилийн хугацаанд тус тэтгэмжийг авсан албан хаагч байхгүй байна. | - |
| 10 | 2.7 | Албан хаагч гэрлэх, хүүхэдтэй болох, хүүхэд үрчлэн авах, хурим хийхэд хүндэтгэл үзүүлэх, чөлөө олгох | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж болон тухайн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгагдсан тохиолдолд | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5.6-д "Албан хаагч гэрлэх, хүүхэдтэй болох, хүүхэд үрчлэн авах, хурим хийхэд хүндэтгэл үзүүлэх, чөлөө олгох" заалт тусгагдсан ба тайлант хугацаанд жижүүр Х.Санжид хурим хийж байгууллагаас 500,000 төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгож ажилласан. | 100% |
| 11 | 2.8 | Албан хаагчид сар бүр унаа, хоолны мөнгөн олговорыг тооцож олгох | Тухай бүр | Холбогдох хууль тогтоомж болон тухайн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д | Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчдад хоол унааны мөнгийг өдрийн 3000 төгрөгөөр тооцож, 9-р сараас эхлэн 5000 төгрөгөөр тооцож олгож байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тусгагдсан тохиолдолд | | |
| 12 | 2.9 | Албан хаагчдыг ажлын зайлшгүй шаардлагаар долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр илүү цагаар ажиллуулсан бол албан хаагчийг ажлын өдөр нөхөн амруулах эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдүүлсэн цалин хөлс олгох | Жилдээ | Холбогдох хууль тогтоомж болон тухайн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгагдсан тохиолдолд | Албан хаагчдын ажил, амралтын цаг, илүү цагаар ажилласан зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журмын 5.4 дэх хэсэгт тусгасан. Албан хаагчдыг ажлын зайлшгүй шаардлагаар амралтын өдөр ажиллуулсан тохиолдолд 2,3 дахь өдөр нөхөн амруулдаг. | 100% |
| 13 | 2.10 | Төрийн албан хаагчид өвлийн улирлын бэлтгэлээ хангахад зориулж нөхөн төлбөр олгох | IV улиралд | Холбогдох хууль тогтоомж болон тухайн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгагдсан тохиолдолд | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5.7-д "Ажилтан албан хаагчдад тухайн жилийн төсөвтөө зохицуулж түлээ, түлшинд дэмжлэг үзүүлнэ" гэж тусгагдсаны дагуу Албан хаагчдад түлшний хөнгөлөлтийг IV улиралд олгоно. | 100% |
| **Гурав. "Салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах зорилтын хүрээнд"** | | | | | | |
| 14 | 3.1 | Албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлийг хангах, өрөө тасалгаанд үе шаттай засвар хийх | Жилдээ | Төсвийн тооцоог гаргасан байх | Хагас жилийн хугацаанп дугуйн бэлтгэлийн өрөөнд бүрэн засвар хийж нийт 4,482,000 төгрөг зарцуулаад байна. | 70% |
| 15 | 3.2 | Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагчийг хамгаалах | Жилдээ | Төрийн албан хаагч ёс зүйн болоод ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | Энэ асуудлаар тайлант хугацаанд ямар нэгэн байдлаар санал, гомдол гараагүй болно | - |
| **Дөрөв. "Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд"** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16 | 4.1 | Албан хаагчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд хамруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | Жилдээ | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан байна. | Энэ оны хагас жилийн хугацаанд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдаа хамруулаагүй байна. | - |
| 17 | 4.2 | Албан хаагдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор ажлын байран дахь дасгал, хөдөлгөөн, төрөл бүрийн урлаг, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах | | Хөдөлмөрийн бүтээмж, эв нэгдэл, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх | Зохион байгуулагдаагүй байна. | 0% |
| Нийт дундаж үнэлгээ | | | | | | 82,8% |

Хэрэгжилт гаргасан: Бичиг хэрэг, архивын ажилтан М.Мөнхжаргал

Хянсан: Дарга Ж.Идэрмөнх